



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 1/55

Мандалговь

Аймгаас 2019 онд дэвшүүлсэн
зорилтыг хэрэгжүүлэхэд шинэ санал санаачилга гаргасан
зарим сумдыг шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 40 дүгээр зүйлийн 40.4.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2020 оны 2 сарын 17-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгаас 2019 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шинэ санал санаачилга гаргасан Баянжаргалан сум, Дэлгэрхангай сумдын Засаг даргын Тамгын газрыг тус бүр аймгийн Засаг даргын "Өргөмжлөл" 1000000 (нэг сая) төгрөгөөр шагнасугай.

Хоёр. Шагналд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аймгаас 2020 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, шинэ санал санаачилга гаргаж үр дүнтэй ажиллахыг нийт сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Шагналд шаардагдах 2120000 (Хоёр сая нэг зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрыг дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Ц.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010435

Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар
сарын 18-ны өдрийн 1/35 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын зориулалт	Тоо ширхэг	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Мөнгөн шагнал (Дэлгэрхангай сум)	1	1000000	1000000
2	Мөнгөн шагнал (Баянжаргалан сум)	1	1000000	1000000
3	Өргөмжлөл	2	60000	120000
	Нийт			2120000